

“ДЦС-4” ТӨХК

Огноо: **2020 оны 04 дүгээр сар 20**

**ХЯНАЛТЫН КАМЕР, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалт/ гэрээний
дугаар: **ХО-2020/21**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ДЦС-IV ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ХО-2020/21 “Хяналтын камер, дагалдах хэрэгсэл нийлүүлэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер нь түүнийг нээсэн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2020 оны 04-р сарын 27-ны өдрийн 10.00 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээх бөгөөд 1 хувийг цаасаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04-р сарын 27-ны** өдрийн **10.30**-т цахим системээр нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж
Захиргааны байр 3-р давхар 311,312 тоот өрөө
Утас:70181309, 7017-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) ТООЗ-д заасан шаардлагууд |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн нэг жилийн санхүүгийн баталгаажсан тайлан Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гүйцэтгэсэн гэрээний хуулбар/ Бусад нэмэлт шаардлага: Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар, Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан дэлгэрэнгүй тодорхойлолт, Сертификат, Зураг ирүүлэх, /Монгол хэл дээр/ Угсралт суурьлуулалт хийх</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 04-р сарын 27-ны өдөр Цаг: 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn Сайтад илгээх бөгөөд нэг хувийг цаасаар ирүүлнэ</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот.Баянгол дүүрэг. 20-р хороо. “ДЦС-4” ТӨХК. Давхар болон өрөөний дугаар: 310 тоот Огноо: 2020 оны 04-р сарын 27-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ХО-2020/21 “Хяналтын камер, дагалдах хэрэгсэл” нийлүүлэх нэг багцаас бүрдэнэ</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ,

БАТЛАВ. ДЦС-4 ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД
ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Б. ГАНХУЯГ



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ № СХА-09

Бараа материалын нэр: Хяналтын камерын дагалдах хэрэгсэл

Ерөнхий шаардлага:

	Техникийн өгөгдөл	Техникийн үзүүлэлт	Нэмэлт шаардлага	Дүйцүүлэх нэршил
1	Бичигч төхөөрөмж	16 суваг	Интернетийн илэрц бүхий байна.	
2	Багтаамж	64 терабайт ба түүнээс дээш	16 сувгаар 180 хоног хадгалах /6MP, 5MP, 4MP, 3MP /	
3	System memory	8Gb ба түүнээс дээш		
4	Hard disk drive	8 hard slot ба түүнээс дээш		
5	Сүлжээний төрөл	LAN1.2 interface 10/100/1000mbps		
6	Ажиллах хүчдэл	220В +- 10%	Тэжээл тасраад сэргэхэд автомат асалтын горимтой байх	
7	Үйлдлийн систем	windows, unix		
8	Ethernet	gigabit 2 ширхэг		
10	Программ хангамж	албан ёсны лицензтэй, Админ хэрэглэчийн эрх бүхий нууцлалтай		
11	Бичлэг хийх арга	үргэлжилсэн тасралтгүй, хөдөлгөөнөөр, сонгосон байдлаар		
12	Бичлэг үзэх хэлбэр	цаг хугацааны хүснэгтээр олон сувгаар, томруулж татах хурдан удаан байдлаар хурд сонгох		
13	Array type	type RAID0, RAID1, RAID5, RAID10 ба түүнээс дээш		
14	Ажиллах температур	0--- +50 °C		
15	Видео гаралт	HDMI, VGA,		


Танилцсан:	Р.Ганбат	ЕИО		Нөөцийн дугаар	ДЦС-4 ТӨХК
Хянасан:	Г. Галбадрах	СХА-ны дарга		Хяналтын камерын дагалдах хэрэгсэл	Техн.тод №.....
					Хуудас№
Гүйцэтгэсэн:	Б.Бямбадорж	СХА-ны инж		Мэдээлэл технологийн	Хуудасны тоо-3

16	Дэлгэц хуваалт	1/4 / 9 / 16		
17	Сүлжээний орчинд ажиллах протокол	DHCP, DynDNS, HTTP, NTP, TCP, UDP		
18	Баталгаат хугацаа	3 жил		
19	Шилэн кабелийн конвертор	single mode & multi mode		
20	Transfer fiber.	multi-mode: 50/125, 62.5/125 or 100/140µm single mode: 8.3/125, 8.7/125, 9/125 or 10/125µm		
21	Залгуурын төрөл	SC-коннектор		
22	Мэдээлэл дамжуулах зай	<20км		
23	Ажиллах хүчдэл	220В±10%		
24	Ажиллах температур	-40 - +70° C		
25	Standard Protocol	IEEE 802.3z 1000Base-TX/FX standard		
26	Operation mode	full duplex mode or half duplex mode		
27	Баталгаат хугацаа	3 жил		
28	Хяналтын дэлгэц	46 инч	Хананы бэхэлгээний хамт	
29	Дэлгэцийн нягтрал	3072x2048 түүнээс дээш		
30	Оролтын стандартууд	HDMI, VGA	HDMI, VGA залгуурын хамт залгуурын урт 15м дээш	
31	Ажиллах хүчдэл	220В ± 10%		
32	Ажиллах температур	0— +50 °C		
33	Төрөл	LED		
34	Баталгаат хугацаа	3 жил		

Камер болон тоног төхөөрөмжүүдийг жагсаалт

Танилцсан:	Р.Ганбат	ЕИО		Нөөцийн дугаар	ДЦС-4 ТӨХК
Хянасан:	Г. Галбадрах	СХА-ны дарга		Хяналтын камерын дагалдах хэрэгсэл	Техн.тод №.....
					Хуудас№
Гүйцэтгэсэн:	Б.Бямбадорж	СХА-ны инж		Мэдээлэл технологийн	Хуудасны тоо-3

	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Хяналтын камер	Ш	10
2	Шилэн кабель 8-12 кор	М	1622
3	Тэжээлийн кабель квг1,5*4	М	788
4	Медиа конвертор мульти моде	Ш	9
5	FTF /шилэн кабелийн хайрцаг/	Ш	9
6	Автомат 1,5А 220В	Ш	9
7	Төмөр шон 9м урттай	Ш	9
8	Гэр хайрцаг/цоож түлхүүрийн хамт/	Ш	9
9	Олон залгуур 2,5м 220В/5А	ш	9
10	Свыч 5 прот	ш	9
11	Ган тросс ф5мм	м	395
12	Шонгийн бэхэлгээ	ш	5
13	Тросс татлага	ш	2
14	Төмөр шон 9м урттай	ш	1
15	Бичигч төхөөрөмж 16 суваг	ш	1
16	Хяналтын дэлгэц 46 инч	ш	1

Танилцсан:	Р.Ганбат	ЕИО		Нөөцийн дугаар	ДЦС-4 ТӨХК
Хянасан:	Г. Галбадрах	СХА-ны дарга		Хяналтын камерын дагалдах хэрэгсэл	Техн.тод №.....
					Хуудас№
Гүйцэтгэсэн:	Б.Бямбадорж	СХА-ны инж		Мэдээлэл технологийн	Хуудасны тоо-3

ХААХ-н дарга О. Гантөмөр танаа


2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан хяналтын камерийн системд хийгдэх

ажлуудын жагсаалт

	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	Хяналтын камер угсарч суурилуулах	ш	10	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу
2	Шилэн кабель татах	м	1622	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК, МЭЗ ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу
3	Тэжээлийн кабель татах	м	788	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК, МЭЗ ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу
4	Төмөр шонгийн нүх ухах	ш	10	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК, МЭЗ ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу
5	Төмөр шон суурилуулах	ш	10	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК, МЭЗ ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу
6	Шилэн кабелийн залгаа хийх	ш	10	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК, МЭЗ ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу
7	Тоног төхөөрөмжийн хайрцаг суурилуулах	ш	10	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК, МЭЗ ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу
8	Бичигч төхөөрөмж, Хяналтын дэлгэц суурилуулж холболт хийх	ш	1	Харуулын хяналтын байр
9	Нийт суурилагдсан камер болон холбогдох тоног төхөөрөмжүүдийн тохиргоо зүгшрүүлэлт хийх	ш	1	Вагон пүү урд тал, Монгол Элс ХХК, МЭЗ ХХК хойд талын шинээр барьсан хашаа дагуу, харуулын хяналтын байр

Дээрх хийгдэх ажлууд нь төлөвлөгөөнд туссан төсөвт өртөгт багтсан болно.

Хянасан: СХА-ны дарга



Г. Галбадрах

Жагсаалт гаргасан: СХА-ны инженер



Б. Бямбадорж

[огноо]

“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нэгж үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.
 - 1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
 - 2) барааны гарал үүслийн гэрчилгээ.

3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

4. Төлбөр (ГЕН – 7)
 - 7.1. Нийлүүлэгчид **Урьдчилгаа төлбөр** олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор төлбөрийг хийнэ.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹

Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд **0,1%-ийн алданги ноогдуулна.**

Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд **0,1%-ийн алданги ноогдуулна.**

Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн **30%-аас** хэтрэхгүйбайна.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ДЦС-4 ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

ЗАХИРАЛ

..... НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас **“ДЦС-4” ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны ___ сарын ___-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **нийлүүлэх ХО-2020/21** г (цаашид “бараа” гэх) (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч 3 сарын хугацаатай гэрээг байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Үнийн санал;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХААХ-ИЙН ДАРГА:

О.ГАНТӨМӨР

“.....” ХХК-ИЙН

МЕНЕЖЕР

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Ч.БЯМБАСҮРЭН

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

С.ДОНИД

